

ДИПЛОМАТ АЛБАНЫ БОЛОВСОН ХҮЧИН БЭЛТГЭХ АСУУДАЛД

ГХЯ-ны ТЗУГ-ын
дэд захирал Бат. Ганболд

Эрхэм эрдэмтэн багш нар аа,
Хүндэт зочид оо,

Дипломат албаны үндэсний боловсон хүчнийг эх орондоо бэлтгэх мэргэжлийн анхны дээд сургууль - Олон улсын харилцааны сургуулийг МУИС-ийг түшиглэн байгуулснаас хойш эдүгээ нэгэн 10 жил өнгөрчээ.

Энэ тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан зохион байгуулж байгаа эрдэм шинжилгээний бага хуралд оролцож, санал бодлоо хуваалцах бололцоо олгосонд талархлаа илэрхийлье.

Эрдэм мэдлэгийн зуун гэгдэх ХХI зуунд шинжлэх ухааны бүхий л салбарт үндэсний боловсон хүчин бэлтгэх нь манай улсын цаашдын хөгжил дэвшилд чухал ач холбогдолтой гэдгийг эрдэмтэн багш та бүхэн сайн мэдэх билээ.

Монгол улсын дипломат албанд 1950-иад оныг хүртэл тусгайлан бэлтгэгдсэн мэргэжлийн боловсон хүчин байгаагүй билээ. Гадаад харилцааны өрнөл хөгжлийн хэтийн төлөвөөс үүдэн дипломат албаны мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх шаардлагатай болсныг манай төр, засгаас анхаарч, 1946 онд ЗХУ-д анхны оюутнуудыг илгээж, анхны мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэснээс хойш 50 жил болж байна. Энэ ойг бид Монгол улсын орчин цагийн дипломат алба үүсч хөгжсөний 90 жилийн ойн арга хэмжээний хүрээнд тэмдэглэж байгаа билээ. Өнгөрсөн хугацаанд Москвагийн ОУХДС-ийг Монголоос 427, Дипломатын академийг 100 хүн төгсч эх орныхоо нийгэм, улс төр, эдийн засгийн бүхий л салбарт үр бүтээлтэй ажиллаж ирлээ.

Гадаад харилцааны салбарт ажиллах мэргэжлийн боловсон хүчнээ манай улс социалист системийн гэгдэж байсан орнуудад тодорхой тоогоор бас бэлтгэсэн юм.

Ардчилсан нийгэм байгуулах явдлыг эрхэм зорилгоо болгон дэвшүүлж, улс төрийн олон намын тогтолцоо төлөвшиж байгаа өнөөгийн нөхцөлд аль нэг тийшээ гуйвж дайвалгүй, Монгол улсын төрийн гадаад бодлогыг тууштай хэрэгжүүлэхийн төлөө чин үнэнчээр ажиллах дипломат мэргэжлийн боловсон хүчнийг боломжтой бүхий л сувгаар бэлдэж, тэднийг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах нөхцлийг бүрдүүлэх явдал ГХЯ-ны боловсон хүчний бодлогын гол асуудал юм. Тиймээс дипломат мэргэжлийн албан хаагчийн хэрэгцээг оновчтой тодорхойлох, тэдгээрийг бэлтгэх ажлыг цэгцтэй зохион байгуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа бөгөөд энэ нь боловсон хүчний

төлөвлөлтийн талаар зөв зохистой бодлого барьж хэрэгжүүлэхтэй холбоотой.

Боловсон хүчний хэрэгцээг тодорхойлоход зөвхөн тооны төдийгүй, чанарыг хамтад нь авч үзэх ёстой юм. Чухам ямар ажил хийлгэхээр боловсон хүчин бэлтгэж байгаа, бэлтгэж байгаа хүн ямар мэдлэг, чадвар эзэмших ёстой вэ гэдэг харилцан уялдаа хамааралтай асуудал. Шинэ зуунд мэдлэг, чадвар сайтай ажилтнаар дипломат албыг бэхжүүлэх, тэднийг давтан сургах, мэргэшүүлэх, мэргэшлийг нь дээшлүүлж хөгжүүлэх явдал боловсон хүчний бодлогын чухал хэсэг болж байна.


Өөрөөр хэлбэл, дипломат албаны мэргэшсэн албан хаагчийн хэрэгцээг оновчтой тодорхойлж бэлтгэх, зөв сонгож авах, давтан сургах, албан тушаал дэвшүүлэх, аттестатчилах, дипломат цол олгох, албан тушаал бууруулах, чөлөөлөх, хилийн чанадад томилох, эгүүлэн татах ажлыг цэгцтэй явуулах явдал чухал байна.

Өнгөрсөн онд УИХ-аар батлагдсан "Дипломат албаны тухай" хуулиар дипломат албанд ажиллаж буй хүмүүс, ялангуяа дипломат ажилтнуудын эрх зүйн байдал, ажлын чадвар, дадлага туршлага, мэргэжил, мэргэшил, гадаад хэлний мэдлэгийн талаар олон улсын жишигт нийцсэн өндөр шалгуур тогтоож, дипломат албыг төрийн тусгай албаны ангилалд оруулсан билээ. Дипломат ажилтны дипломат цолыг дахин хуульчлан тогтоож олон улсын жишигт нийцүүлэв. Чингэснээр дипломат албанд ажиллагсдын үүрэг, хариуцлага өндөржиж байгаа хэрэг юм.

Олон улсын хэмжээнд дипломат үйл ажиллагааг төрийн мэргэшсэн тусгай алба эрхлэн явуулдаг, түүний ажиллах боловсон хүчнийг мэргэжлийн их, дээд сургуульд бэлтгэж, өндөр шалгуураар сонгон авдаг, тэрхүү мэргэжлийг эзэмшиж, олон улсын харилцааны салбарт улс орноо төлөөлөн хилийн чанадад ажиллаж байгаа төрийн албан хаагчийг дипломатч гэж томъёолон тусгай эрх дарх эдлүүлдэг нь дэлхий нийтийн жишиг юм. Ийм ч учраас дээрх хуульд *дипломат алба нь төрийн тусгай алба мөн* гэж тодорхойлсон билээ.

Дипломат арга ажиллагааг аливаа улсын гадаад бодлогын нэн чухал арга хэрэгслийн нэг гэж дэлхий нийтээр үздэгийн хувьд тусгай алба мэргэжил гэдэг. Энэ мэргэжлийг сургууль номоос гадна, олон жилийн туршлагаар олж авдаг нь үнэн юм. Дипломат шиг олон талтай мэргэжил нэгээхэн ч үгүй гэж соёлт ертөнцөд үздэг байна.

Гадаад хэргийн яам, түүний системийн үйл ажиллагаа нь үнэн хэрэгтээ Монгол Улсын нэрийн хуудас мөн. Ийм ч учраас ГХЯ урьд нь өөрийн үйл ажиллагааны дотоод дэг журам, баримт бичгийн боловсруулалт, харилцааны соёлд онцгой анхаарч ирсэн бөгөөд түүгээрээ ч бусад байгууллагаас ялгардаг байсан. Манай ахмадууд бидэнд өндөр шаардлага тавьж, "элдүүрийг нь ханатал" ажиллуулж байсны ач буянаар бидний үеийнхэн ахмадаасаа бага ч гэсэн зүйл суралцан ажлын дөртэй болцгоосон билээ. Ахмад, залуу үеийн холбоо хэдийд ч гэсэн байх ёстой. ГХЯ-ны ажлын чанар, түвшинд ажиллагсдынх нь мэргэжлийн ур чадвар, ажил албаны туршлага ихээхэн нөлөөтэй нь ойлгомжтой юм.



Дипломат албаны хуулийн заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус яаманд ажиллах сонирхолтой олон улсын харилцааны мэргэжил эзэмшсэн иргэдийг дипломат албаны мэргэжлийн уралдаант шалгалтаар сонгон шалгаруулж авах журамд шилжээд байна.

“Дипломат албаны тухай” Монгол улсын хуульд “дипломат албан тушаалд томилогдох иргэн нь олон улсын харилцаа, эрх зүй, эдийн засаг, улс төр, онолын зохих бэлтгэлтэй, дээд боловсролтой, хоёр буюу түүнээс дээш гадаад хэлийг ажлын шаардлагын түвшинд эзэмшсэн байхын зэрэгцээ төрийн дипломат тусгай албаны уралдаант шалгалтыг өгч тэнцсэн, тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан, биеийн эрүүл мэнд сайтай, ёс зүйн аливаа зөрчилгүй байна” гэж заасан.

Дээрх шаардлагыг хангахуйц мэргэжлийн боловсон хүчнийг дотооддоо болон хилийн чанадад оновчтой төлөвлөж бэлтгэхэд ГХЯ-ны удирдлага, захиргаа анхаарч, ойрын 10 жилийн стратеги төлөвлөгөө боловсруулан боловсон хүчнийг бэлтгэх, байршуулах, мэргэшүүлэх, давтан сургах, албан тушаал, дипломат цол ахиулах, бууруулахтай холбогдсон тусгай журам гарган мөрдөж байна.

ГХЯ боловсон хүчний бодлогоо цаашид “Дипломат албаны тухай” хуульд нийцүүлэн хэрэгжүүлнэ. Энэ оноос гадаад, дотоодод дипломат болон бусад мэргэжлээр их, дээд сургууль төгсөөд ирсэн хүмүүсээс уралдаант шалгалтыг хуулийн дагуу авч хамгийн өндөр оноо авсан хүмүүсээс ажлын байрны боломжоо харгалзан заримыг нь ажилд авч байршуулах ажлыг зохион байгуулж эхлээд байна. Энэ зарчим цаашид ч хэрэгжинэ. Өөрөөр хэлбэл, мэргэжил, гадаад хэлний хувьд сайтар бэлтгэгдсэн боловсон хүчин манай уралдаант шалгалтад чөлөөтэй орж өрсөлдөх, улмаар ажлын байраар хангагдах өргөн боломж байгаа юм шүү. Энэ онд уралдаант шалгалтад орсон 40 гаруй хүний дотор Олон улсын харилцааны сургуулийн төгсөгч нэг байсныг дашрамд тэмдэглэе.

Ер нь дипломат мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх тухайд ГХЯ шаардлагатай боловсон хүчнээ төрийн сангийн зээлээр дотоод, гадаадын их, дээд сургуульд тодорхой чиглэлээр бэлтгэх чиглэл барина. Тодорхой чиглэл гэдэг нь яамны боловсон хүчин бэлтгэх стратеги төлөвлөгөө, ажлын тодорхой хэрэгцээ, шаардлагыг харгалзана гэсэн үг юм. Сургах хүмүүсийг уралдаант шалгалтаар сонгон авч гэрээ байгуулна. Суралцах хугацаандаа гэрээний нөхцлийг биелүүлээгүй, төгсөөд уралдаант шалгалтад тэнцэхгүй бол байгуулсан гэрээг цуцалж, гарсан зардлыг өөрөөр нь нөхөн төлүүлнэ.

Боловсон хүчнийг нэгэнт л сонгож шалгаруулаад ажилд авсан бол тэдний өсч дэвжих, өөрийгөө хөгжүүлэх хүсэл эрмэлзлийг аль болох дэмжиж, давтан сургалтад хамруулах чиг барина. Чингэхдээ ажлын шаардлага, тухайн ажилтны ажил хэрэгч байдал, өсөх ирээдүй, суралцах чиглэл зэргийг харгалзах нь мэдээж.

Дипломат ажилтнуудыг мэргэжил, гадаад хэлний мэдлэг, сонирхол зэргийг нь харгалзан тодорхой чиглэлээр аль болох дагнуулан мэргэшүүлэх чиглэл баримталж байна.

Ажлын дадлага олгох зорилгоор шинэ тутам ажилд орсон ажилтнуудыг хилийн чанад дахь ДТГ-уудад тодорхой хугацаагаар дадлага хийлгэж байгаагийн зэрэгцээ, гадаадын урт, богино хугацааны давтан сургалтад өргөнөөр хамруулах ажил зохиож байна. Тухайлбал, тус яамны ажилтнуудаас жилд 15-20 хүн урт, богино хугацааны мэргэжлийн болон гадаад хэлний мэдлэг дээшлүүлэх давтан сургалтад хамрагдаж байгаа болно.

Ажил, амьдрал дээр харахад манай ОУХС-ийг урьд жилүүдэд төгсөөд төрийн албаны шалгалт өгч тус яаманд ажилд орсон залуучуудын гадаад хэл, мэргэжлийн бэлтгэл ажлын шаардлагын түвшинд хүрэхгүй байна. Тэдний гадаад хэлний мэдлэг, мэргэжлийн түвшин хангалтгүй, гадаад хэлээр бүү хэл төрөлх монгол хэлээрээ бичиг баримт боловсруулах дөргүй хүмүүс ирж байна. Эзэмшсэн гадаад хэлээрээ аман болон бичгийн орчуулга хийж буй байдал туйлын хангалтгүй, улс орон, бүс нутгийн асуудлаар ч гүнзгий мэдлэггүй байна.

Танай сургуулиас төрөн гарч буй "Гадаад албаны ажилтан" нь улс орны нийгмийн бүхий л салбарт олон улсын харилцаа, олон улсын эрх зүй, эдийн засаг, улс төрийн онолын өндөр мэдлэгтэй, 1-2 түгээмэл гадаад хэл төгс эзэмшсэн, улс орон, бүс нутгийн асуудлаар мэргэшсэн боловсон хүчин байх аваас мэдээллийн технологийн эрин зууны шаардлагад нийцэх болно.

Гадаад харилцааны албаны ажилтанд судалгааны досье бүрдүүлэх ажлын талаар онолын мэдлэг, практик дадлага олгох шаардлагатай байна. Олон улсын болон харилцааны асуудлаар досье бүрдүүлэх, баяжилт хийх талаар тодорхой ойлголтгүй байгаагаас улс орнуудтай хөгжүүлэх харилцаа, хамтын ажиллагааг үндэслэл, судалгаа сайтай эрхлэн явуулахад тодорхой бэрхшээл гарна. Тухайлбал, бичиг баримт боловсруулахдаа тухайн асуудлын үүсч гарсан учир шалтгаан, өрнөл, үйл явцыг баримтад түшиглэж гаргалгүй ерөнхийлөн хандах, асуудлынхаа гүнд орохгүй байдал ажиглагдана. Иймд энэ асуудал ОУХС-ийн сургалтын хөтөлбөрт тусгагдах ёстой гэж үзэж байна.

Мөн төрөлх болон эзэмшиж буй хэлээрээ бичиг баримт боловсруулах ур чадвар олгох, төрийн нууцын зэрэглэлтэй баримт бичигтэй харьцах талаар дадлага эзэмшүүлэхэд ч анхаарахад илүүдэхгүй.

Судалгаанаас үзэхэд манай орны гадаад харилцааны мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургуулийн тоог хүн амын өсөлт, нийгмийн хэрэгцээ шаардлагатай жишиж үзэхэд харьцангуй олон байна. Сургууль төгсөгчдийн чанарын үзүүлэлт ч доогуур байгаа юм.

Иймд дипломат албаны боловсон хүчнийг мэргэжлийн их, дээд сургуульд тусгай хөтөлбөрөөр онолын өндөр түвшинд бэлтгэдэг олон улсын жишгээр Олон улсын харилцааны сургуулийн байр суурийг улам бататгаж, эрдэм мэдлэгийн уурхай, судалгааны төв болгоход төр, засгийн бодлого чиглэх ёстой гэж үзэж байна.

Гадаад хэргийн яам тодорхой түвшний мэдлэг эзэмшсэн, гадаад харилцааны ажлын туршлагатай, ер нь төрийн бодлоготныг бэлтгэж ажиллуулах шаардлагатай байгууллага болохын хувьд бэлтгэгдсэн

боловсон хүчиндээ хянуур анхааралтай хандаж, залуу боловсон хүчнийг тодорхой зорилго, чиглэлтэй бэлтгэж, тогтвортой мэргэшүүлэн, тэдний сургалт, практикийг хослуулахад анхаарч, мэргэжилтэнд өөрийгөө харуулах боломж олгож ажилладаг юм. Ажил мэргэжлээрээ өсч байгаа ажилтны л албан тушаал ахиж байх зарчим баримталж, ажлын үр дүнгээр нь үнэлэх систем хэрэгжиж байна.

Дипломатчид улс орныхоо эрх ашгийг урьтал болгодог чанар, ажил мэргэжилдээ дур сонирхолтой байдал, үнэнч шударга зан, мэргэжлийн онолын мэдлэг, ур чадвар, гадаад хэл төгс эзэмшсэн байдлаараа бусдаас ялгардаг байх ёстой.

ОУХС төгсөгчид нь тус яаманд ажиллах хүсэлтэй байх нь зүйн хэрэг. Гэхдээ залуучууд цаашид уралдаант шалгалтын бүхий л шалгуурыг заавал давах ёстой болно гэдгийг ойлгуулж сайн мэргэжилтэн болохын төлөө биеэ дайчлах ёстойг ухааруулж байх нь зүйтэй болов уу.

Манай дипломат албаны боловсон хүчинд тавих шаардлагыг хангасан боловсон хүчин бэлтгэх эрхэм зорилтоо хэрэгжүүлэх үйлсдээ амжилт олохын ерөөл дэвшүүлье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

The report is chronological description of diplomatic training of Mongolia. It states that since 1946 almost all diplomats have been trained and re-trained in former socialist countries, primarily, in Moscow Institute of International Relations, Diplomatic Academy of the USSR. Reporter notes that since 1990 this duty has been relayed to the School of Foreign Service of the NUM. The report covers also aspects of preparing training of diplomats, selection career diplomats as well as promotion, posting and recalling them according to the recent law on "Diplomatic service".